*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТ-УНДРАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Эрүүл мэндийн сайдын багцын эмнэлгийн болон бусад тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт, зохицуулалт, тайлагналт, мэргэжлийн арга зүйгээр хангах үйл ажиллагаа** | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ. 2.3.2.1 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 50 | 60 | Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэй Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах” төслийн хүрээнд нийлүүлэх гэрээний дагуу 4,649,3 сая төгрөгийн Уян дурангийн иж бүрдэл (тус бүр 4 дурантай), Ходоодны дуран (дангаар), Суурин эхо аппарат, LEEP аппарат, иж бүрдэл тоног төхөөрөмжийг аймгуудын нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд, Эрүүл мэндийн сайдын нөөцийн тоног төхөөрөмжөөс орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 975.1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангасан байна. Энэ нь нийт 24 нэр төрлийн 377 ширхэг 5.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг 88 орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэн | 1-12 сар | 50% |

(10)

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төвлөрөлийг сааруулах зорилгоор хуваарилан олгосон. | | |
| 2. | ЗГҮАХ 2.3.2.1<br><br>Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлтийг хийнэ. | Хүлээлгэн өгсөн машины тоо | 135 | 5 | Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлтийн хүрээнд 2025 онд Увс аймгийн Бөхмөрөн, Тариалан, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Ховд аймгийн Дарви сумын эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай бүрэн тоноглогдсон 1,044.5 сая төгрөгийн төсөвтэй 5 машинаар хангасан байна. | 1-12 сар | 100%<br>(80) |
| 3 | МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын / XXII.3.1- XXII. 3.4/ Эрүүл мэндийн салбарын төсөл арга хэмжээний тоног төхөөрөмжийн шилжих 1, шинэ 3 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжилтийг хангах | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | 30% | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийт 69.8 тэрбум төсөвт бүхий 4 төсөл, арга хэмжээ батлагдсанаас шилжих 1, шинээр хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс эхний хагас жилийн байдлаар шилжих төсөл арга хэмжээний 0,5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Шинэ төсөл арга хэмжээнд 6.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдан, бусад төсөл арга хэмжээ нь төрийн худалдан авах ажиллагааны газар худалдан авалтыг зохион байгуулсан болович Төрийн хэмнэлтийн тухай хуулиар тендер түр зогсон, төсвийн тодотгол хийгдэхээр байна. | 07 дугаар сарын 25 дотор | 20%<br>(10) |
| 4 | Эрүүл мэндийн сайдын багцын тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний хуваарилалтын тушаалыг боловсруулан, батлуулах | Тоног төхөөрөмж хуваарилсан тушаал батлуулах | | 50% | Эрүүл мэндийн сайдын багцын тоног төхөөрөмжийн хуваарилалтыг 2025 оны А/29, А/106, А/107, А/108, А/167, А/234 тушаалыг батлуулан, 19.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг аймаг, нийслэлийн | 1-12 сар | 100%<br>– ? |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрүүл мэндийн байгууллагад хуваарилан, олгосон. | | |
| Зорилт 2. Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын цахим систем болон судалгаа, мэдээний сангийн үйл ажиллагаа, салбарын санхүүгийн нэгдсэн тайланд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын мэдээ, мэдээллийг нэгтгүүлэх, тайлагнах үйл ажиллагаа | | | | | | | |
| 1 | Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллагын саналыг үндэслэн зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулах | Батлагдсан тушаалын тоо | | 15 | Эрүүл мэндийн сайдын багцын задаргааг А/19 тушаалаар 16 багц болгон задлан, тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолтыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/120, А/122, А/123, А/124, А/136, А/137, А/147, А/148,А/149, А/150, А/156, А/157, А/158, А/159, А/160, А/161, А/162, А/163 тушаалаар батлан Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар холбогдох материалыг хүргүүлсэн. | 1-12 сар | 100% -70 |
| 2 | Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2027-2028 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | Төсвийг нэгтгэн тайлан, хүргүүлсэн албан бичиг, батлагдсан хууль | | 100% | Эрүүл мэндийн салбарт 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн хүрээний мэдэгдэлд 88 төсөл арга хэмжээний 1.016.777,4 тэрбум төгрөгийн саналыг 2025-04-03-ны 1а/1618, Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны төсвийн хязгаарыг 12 төсөл арга хэмжээний 550.000,0 тэрбум төгрөгийн саналыг 2025-06-06 өдрийн 1а/3034 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 1-12 сар | 100% |
| 3 | Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн | Төсвийг нэгтгэн тайлан, хүргүүлсэн албан бичиг, батлагдсан хууль | | 100% | Хуулийн хугацаа болоогүй | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | яаманд санал хүргүүлж, батлуулна. | | | | | | |
| 4 | Эрүүл мэндийн салбарт хэрэгжих хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох, тайлагнах | Санхүүжилтийн хувь | | 30% | Эрүүл мэндийн сайдын багцын тоног төхөөрөмжийн 10 төсөл, арга хэмжээний 8,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг холбогдох журмын дагуу хянан баталгаажуулж, 2025 оны 06 дугаар сарын байдлаар олгосон байна. | 1-12 сар | 10% |
| 5 | Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн системд мэдээллэх | Төсөл арга хэмжээний тайлан | | 50% | Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн системд тоног төхөөрөмжийн гэрээ, санхүүжилт, хуваарилалтын тушаалыг хуулийн хугацаанд оруулсан. | 1-12 сар | 50% |
| **Зорилт 3.** Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан ажлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах | Боловсруулсан мэдээллийн тайлан | | 100% | 2025 оны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны тайланг гарган сар бүрийн мэдээг тайлагнасан ажилласан. Үндэсний аудитын газарт Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тайлан, холбогдох мэдээллийг гарган хүргүүлсэн. | 1-12 сар | 100 |
| 2 | Хариуцсан ажлын хүрээнд ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь | | | 2025 оны 06 сарын байдлаар 323 бичиг хүлээн авсанаас шийдвэрлэсэн 169 буюу 91,8 хувийн шийдвэрлэлттэй. Хариугүй бичиг нь 139 буюу тайлан харьяа байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл болно. | 1-12 сар | 50 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д /д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдах | Удирдлагын академийг төгсөн, гэрчилгээг авсан байх | | 100% | Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдан. Ахлах түшмэлийн гэрчилгээгээ авсан | 10-2 сар | 100 |
| 2 | Мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалт, семинарт оролцох | Сургалт, семинарын тоо-3 | | 3 | Эдийн засаг хөгжлийн яамнаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | 4 сар | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн | Б.Бат-Ундрал / ........................ / | 2025/06/13 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |